



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/148/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Оюунжаргал Утас:99460422 Цахим хаяг: oyunjargald@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	3
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

№ _____
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

012025386

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТУНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,136.72	51,425.57
33	АВЛАГА	230.42	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	230.42	-
35	БАРАА МАТЕРИАЛ	39,906.29	51,425.57
351	Түүхий эд материал	165.00	804.00
35130	Эм боох материал	165.00	804.00
354	Хангамжийн материал	35,649.29	46,025.57
35410	Бичиг хэргийн материал	42.95	85.95
35420	Аж ахуйн материал	2,946.88	4,216.88
35450	Барилгын засварын материал	65.00	1,487.29
35460	Хүнсний материал	4,408.22	7,817.37
35470	Бусад хангамжийн материал	28,186.25	32,418.09
35600	Мал амьтад	4,092.00	4,596.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	673,374.97	657,090.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	673,374.97	657,090.78
392	Биет хөрөнгө	663,923.47	647,969.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	670,554.23	670,554.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,114.23)	(51,734.23)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,947.04	44,894.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,667.85)	(28,730.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,188.06	30,106.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,284.60)	(18,191.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,058.14	13,873.34
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,845.42)	(13,583.34)
39217	Ном	1,088.10	780.30
393	Биет бус хөрөнгө	9,451.50	9,121.50
39301	Програм хангамж	1,900.00	1,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(442.50)	(772.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,994.00	7,994.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	713,511.68	708,516.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	713,511.68	708,516.36
51	Засгийн газрын хувь оролцоо	713,511.68	708,516.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,707.96	37,707.96
51101	Өмч: - төрийн	37,707.96	37,707.96
512	Хуримтлагдсан үр дүн	672,691.14	667,695.82
51210	Өмнөх үеийн үр дүн	672,691.14	672,691.14
51220	Тайланг үеийн үр дүн	-	(4,995.33)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,112.58	3,112.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	713,511.68	708,516.36

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	201,263.40	209,287.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,915.00	3,618.34
120	Нийтлэг татварын бус орлого	4,915.00	3,618.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,915.00	3,618.34
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжилт	1,416.00	2,878.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499.00	740.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,348.40	205,669.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	184,576.80	182,576.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,576.80	182,576.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,136.00	2,865.44
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,136.00	2,865.44
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,635.60	20,227.40
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,635.60	20,227.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	217,430.08	213,974.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,430.08	213,974.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	197,029.29	212,859.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,208.46	131,384.90
210101	Үндсэн цалин	90,332.96	92,363.90
210102	Нэмэгдэл	25,695.43	28,694.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	270.00	500.00
210104	Урамшуулал	8,910.07	9,826.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,063.45	17,163.61
210201	Тэтгэврийн даатгал	11,726.51	11,864.21
210202	Тэтгэмжийн даатгал	1,132.33	1,324.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	854.95	1,059.90
210204	Ажилгүйдлийн даатгал	212.75	265.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,136.91	2,649.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,817.87	18,718.30
210301	Гэрэл, цахилгаан	900.04	804.69
210302	Тулш, халаалт	8,233.50	17,213.62
210303	Цэвэр, бохир ус	684.33	700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,930.99	5,425.80
210401	Бичиг хэрэг	1,105.70	609.00
210402	Тээвэр, шатахуун	513.80	1,031.60
210403	Шүүдэл, холбоо, инженерийн төлбөр	477.00	425.83
210404	Ном, хэвлэл	21.00	40.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,813.49	2,693.08
210408	Бараа материал акт алсны зардал	-	625.50
2105	Нормативт зардал	12,196.37	11,166.15
210501	Эм, бэлчмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,367.40	1,893.40
210502	Хоол, хүнс	8,264.98	7,782.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,564.00	1,490.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,120.80	2,918.95
210604	Урсгал засвар	2,120.80	2,918.95
2107	Томилголт, зочны зардал	612.20	928.50
210702	Дотоод албан томилолт	612.20	928.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	237.30	367.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225.30	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	367.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,841.85	24,785.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	1,117.35	973.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,724.50	23,812.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,400.79	1,115.31
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,400.79	1,115.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,400.79	1,115.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16,166.68)	(4,686.69)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,386.00	163.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,386.00	163.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,327.11	471.63
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	471.63
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,327.11	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(941.11)	(308.63)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,107.79)	(4,995.33)

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	196,348.40	205,669.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,348.40	205,669.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	184,576.80	182,576.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,576.80	182,576.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,136.00	2,865.44
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,136.00	2,865.44
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,635.60	20,227.40
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,635.60	20,227.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	194,648.40	198,409.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	194,648.40	198,409.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,247.61	197,294.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,208.46	131,384.90
210101	Үндсэн цалин	90,332.96	92,363.90
210102	Нэмэгдэл	25,695.43	28,694.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	270.00	500.00
210104	Урамшуулал	8,910.07	9,826.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,293.88	16,933.19
210201	Тэтгэврийн даатгал	11,956.94	11,633.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,132.33	1,324.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	854.95	1,059.90
210204	Ажилгүйдлийн даатгал	212.75	265.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,136.91	2,649.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,796.83	18,718.30
210301	Гэрэл, цахилгаан	879.00	804.69
210302	Түлш, халаалт	8,233.50	17,213.62
210303	Цэвэр, бохир ус	684.33	700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,563.25	4,761.40
210401	Бичиг хэрэг	767.20	652.00
210402	Тээвэр, шатахуун	513.80	1,031.60
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	477.00	425.83
210404	Ном, хэвлэл	21.00	40.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,784.25	2,611.18
2105	Нормативт зардал	14,384.75	16,965.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,532.40	2,532.40
210502	Хоол, хүнс	10,444.25	10,802.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,408.10	3,630.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,959.10	4,341.24
210604	Урсгал засвар	1,959.10	4,341.24
2107	Томилолт, зочны зардал	612.20	928.50
210702	Дотоод албан томилолт	612.20	928.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	237.30	367.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225.30	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	367.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,191.85	2,893.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,191.85	2,893.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,400.79	1,115.31
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,400.79	1,115.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,400.79	1,115.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,700.00	7,260.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,700.00	7,260.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,700.00	7,260.10
2200	Дотоод эх үүсвэрээр	1,700.00	7,260.10
223001	Бусад хөрөнгө	-	7,260.10
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,700.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,700.00)	(7,260.10)

2.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,707.96	1,254.23	691,657.29	730,619.48
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,707.96	1,254.23	691,657.29	730,619.48
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	(17,107.79)	(17,107.79)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,707.96	3,112.58	672,691.14	713,511.68
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,707.96	3,112.58	672,691.14	713,511.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,707.96	3,112.58	672,691.14	713,511.68
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	(4,995.33)	(4,995.33)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,707.96	3,112.58	667,695.82	708,516.36

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,344.40	92,344.40	201,621.30	194,428.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,344.40	92,344.40	201,621.30	194,428.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,271.10	92,271.10	201,621.30	194,428.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,196.00	63,609.25	131,403.00	131,384.90
210101	Үндсэн цалин	54,358.30	54,358.30	92,382.00	92,363.90
210102	Нэмэгдэл	3,826.80	3,724.05	28,694.60	28,694.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	500.00	500.00
210104	Урамшуулал	6,010.90	5,526.90	9,826.40	9,826.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,298.20	6,997.02	16,933.20	16,933.19
210201	Тэтгэврийн даатгал	4,588.30	4,452.65	11,677.80	11,633.79
210202	Тэтгэмжийн даатгал	542.00	508.87	1,313.80	1,324.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	677.40	636.09	1,051.10	1,059.90
210204	Ажилгүйдлийн даатгал	135.50	127.22	262.80	265.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,355.00	1,272.19	2,627.70	2,649.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,206.10	7,479.57	19,404.30	18,718.30
210301	Гэрэл, цахилгаан	450.00	361.31	879.00	804.69
210302	Түлш, халаалт	3,551.10	6,937.02	17,825.30	17,213.62
210303	Цэвэр, бохир ус	205.00	181.24	700.00	700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	353.90	1,647.66	4,793.60	4,761.40
210401	Бичиг хэрэг	32.40	121.50	544.20	652.00
210402	Гээвэр, шатахуун	151.60	606.06	1,113.80	1,031.60
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	60.80	420.00	430.00	425.83
210404	Ном, хэвлэл	11.70	25.00	40.80	40.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97.40	475.10	2,664.80	2,611.18
2105	Нормативт зардал	15,394.10	11,467.97	16,880.00	16,965.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16.60	31.60	1,216.10	2,532.40
210502	Хоол, хүнс	15,166.50	11,404.37	10,802.80	10,802.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	211.00	32.00	4,861.10	3,630.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214.60	74.80	823.10	1,475.80
210604	Урсгал засвар	214.60	74.80	823.10	1,475.80
2107	Томилолт, зочны зардал	87.00	282.00	928.50	928.50
210702	Дотоод албан томилолт	87.00	282.00	928.50	928.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57.20	194.63	367.30	367.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57.20	194.63	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	367.30	367.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.46	0.52	10.09	2.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	464.00	518.20	10,088.30	2,893.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.07	0.07	-	-
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	73.30	73.30	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	73.30	73.30	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	7,260.10
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	7,260.10
223001	Бусад хөрөнгө	-	-	-	7,260.10
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,344.40	92,344.40	201,621.30	202,804.10
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	92,244.40	92,244.40	181,393.90	182,576.70
131001	Улсын төсвөөс санхүүжих	92,244.40	92,244.40	181,393.90	182,576.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	20,227.40	20,227.40
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	20,227.40	20,227.40
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100.00	100.00	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Д.Оюунжаргал гүйцэтгэж, хяналтыг Ахлах аудитор Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн нь 2021-2022 оны хичээлийн жилд "Хүүхдээ дээдэлж багшаа хөгжүүлж, хүүхэд хөгжих таатай орчинд чанартай сургалтыг эрхэмлээ" зорилтыг тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 209,3 сая төгрөгийн 1 хувиар буюу 2,1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	230,4	-	-230,4
Бараа материал	39,906.3	51,425.6	11,519.3
Үндсэн хөрөнгө	673,374.9	657,090.8	-16,284.1
Нийт хөрөнгө	713,511.7	708.516.4	-4,995.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	713,511.7	708.516.4	-4,995.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	713,511.7	708.516.4	-4,995.3

Бараа материалын дансны үлдэгдэл 11,5 сая төгрөгөөр өссөн нь эм, ороох боох материал, хүнс болон бусад бараа материалын худалдан авалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,5 сая төгрөгөөр буурсан нь цэцэрлэгийн хуучин үндсэн актлагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 198,0 сая төгрөгөөр, 198,0 сая төгрөгөөр нийт зарлагыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 20,2 сая төгрөгийн, улсын төсвөөс 182,6 сая төгрөгийн, нийт 202,8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 194,4 сая төгрөгийг зарцуулж, 7,3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1,1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 2,8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч урсгал засварт зарцуулсан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Бусад хангамжийн материалын зардлаас багш нарт биеийн тамирын хувцас 1,8 сая төгрөгөөр худалдан авч олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолыг тус тус зөрчсөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 1,8 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрсэн.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроон, 141 мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилтийг 2021.05.31-ны №14 тоотой ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2021 оны 10 сарыг 29-ны өдрийн 190 тоот тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн анилал, ашиглах заавар”-ын хэрэгжилт

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0,7 сая төгрөгийн алдааг залруулж, 1,8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Залруулсан алдаа

0,7 төгрөгийн бараа материалын тодруулгын алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт: 1,8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

өгөдөөгүй

Тогтоосон төлбөрийн актын биелэлтийг аймгийн төрийн сангийн бусад нэр заагдаагүй орлогын 100090000955 оот дансанд 2022 оны 05 дугаар сарын 25 -ны дотор төвлөрүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Улиастай сумын 1-р цэцэрлэг	2	2,5	1	0,7	1	1,8				